



## ОНЦЛОХ МЭДЭЭ:

- 2014 оны эхний 3 улирлын байдлаар урсгал тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 дахин буурлаа.
- Монгол Улсын гадагш хийсэн хөрөнгө оруулалтын үлдэгдэл буурч байхад гадаадаас Монголд оруулсан хөрөнгө оруулалтын үлдэгдэл нэмэгдсэн нь хөрөнгө оруулалтын богино позиц нэмэгдэхэд нөлөөлжээ.
- Монгол Улсын нийт гадаад зээлийн үлдэгдэл 21 тэрбум ам.долларт хүрээд байна.

## АГУУЛГА

Төлбөрийн тэнцэл	2
Гадаад хөрөнгө оруулалтын позиц	4
Нийт гадаад зээл	5
Хавсралт	6

## Валют, эдийн засгийн газрын Төлбөрийн тэнцлийн статистик, судалгааны хэлтэс

Монголбанк  
Бага тойруу 3,  
Улаанбаатар 15160  
Утас: 976-11-323243,  
327086, 327088

Факс: +976-11-327088  
Email:  
bor@mongolbank.mn

## Төлбөрийн тэнцэл (BOP)

2014 оны 3-р улиралд (7-9 сарууд) урсгал данс 320 сая ам.долларын алдагдалтай, хөрөнгө ба санхүүгийн данс 657 сая долларын ашигтай, алдаа ба орхигдуулга -165 сая ам.доллар гарснаар, төлбөрийн нийт тэнцэл 172 сая ам.доллар болж, гадаад валютын албан нөөц уг дүнгээр өөрчлөгдлөө.

2013 оны 3-р улиралтай харьцуулахад урсгал дансны алдагдал 488 сая ам.доллараар буурч, хөрөнгө ба санхүүгийн дансны ашиг 611 сая ам.доллараар нэмэгдсэн байна.

Хөрөнгө, санхүүгийн дансыг бүтцээр нь авч үзвэл ШХО-ын ашиг 196 сая ам.доллараар буурч, багцын ХО-ын алдагдал 25 сая ам.доллараар буурч харин бусад ХО-ын алдагдал 837 сая ам.доллараар өссөн байна.

## Гадаад хөрөнгө оруулалтын позиц

Монгол Улсын гадаадад байршуулсан санхүүгийн хөрөнгө (актив) 3,569 сая ам.доллар, гадаадад төлөх санхүүгийн өглөг (пассив) 27,058 сая ам.долларт тус тус хүрснээр гадаад хөрөнгө оруулалтын позиц улирлын эцэст 23,490 сая ам.долларын сөрөг үлдэгдэл буюу богино байна.

Энэ нь Монгол Улс цэвэр дүнгээр гадаадад төлөх санхүүгийн өглөгтэй болохыг харуулж байгаа бөгөөд богино позиц нь өнгөрсөн оны мөн үеэс 25% буюу 4.3 тэрбум ам.доллараар нэмэгдсэн.

Үүнд: ШХО-ийн богино позиц 1.5 тэрбум, багцын ХО 0.4 тэрбум, бусад ХО-ын эх үүсвэр 1.3 тэрбум ам.доллараар тус тус өсч, ГВУН 1.2 тэрбум ам.доллараар буурсан нь нөлөөлжээ.

## Гадаад өрийн статистик

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2014 оны 3-р улирлын гүйцэтгэлээр 20,951 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 15%-иар буюу 2,671 сая ам.доллараар нэмэгдсэн байна.

Үүнд: Засгийн газар болон Төв банкны гадаад өр өнгөрсөн оны мөн үеэс 11%-иар буюу 482 сая ам.доллараар өсч 5,031 сая ам.долларт, хувийн хэвшлийн салбарын гадаад өр 16%-иар буюу 2,189 сая ам.доллараар нэмэгдэн 15,919 сая ам.долларт хүрээд байна.

## Гадаад секторын статистик гэж юу вэ?

Гадаад секторын статистик гэж аливаа улс орны гадаад ертөнцтэй харилцах эдийн засгийн харилцааг үзүүлэгч эдийн засгийн төлбөр тооцооны дансдын урсгал болон үлдэгдлийн мөнгөн үзүүлэлтийг хэлдэг.

Энэхүү үзүүлэлтэд төлбөрийн тэнцэл, гадаад хөрөнгө оруулалтын позиц, гадаад зээл, гадаад валютын улсын нөөцийн мэдээ зэрэг статистик мэдээллүүд багтдаг.


Дүрслэл 1. Төлбөрийн тэнцэл




Дүрслэл 2. Гадаад хөрөнгө оруулалтын позиц



Дүрслэл 3. Нийт гадаад өрийн үлдэгдэл



Дүрслэл 4. Статистик хамаарал



# I. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

## УРСГАЛ ДАНС

Тайлант улиралд урсгал тэнцлийн алдагдал 320 сая ам.доллар гарч, алдагдлын хэмжээ 2013 оны мөн үеэс 60%-иар буурчээ.

Бараа, үйлчилгээний худалдааны алдагдал өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 639 сая ам.доллараар буурсан нь барааны алдагдал 734 ам.доллараар буурч 240 сая ам.долларын ашигтай гарсантай холбоотой байна.

## Барааны худалдаа

Төлбөрийн тэнцэл дэх барааны худалдааны эргэлт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 8%-иар өсч 2,843 сая ам.долларт хүрсэн. Барааны худалдааны тэнцэл тайлант хугацаанд эерэг тэмдэгтэй 240 сая ам.долларт хүрч, 3 улирал дараалан ашигтай гарлаа.

Барааны худалдааны тэнцэл сайжрахад зэсийн баяжмал, боловсруулаагүй нефтийн экспортын өсөлт болон хүнд даацын машин, механизм, тоног төхөөрөмж, бүх төрлийн автомашин, нефтийн бүтээгдэхүүний импортын бууралт зэрэг нь голлон нөлөөлсөн.

## Үйлчилгээний худалдаа

Тайлант улирлын үйлчилгээний орлого өнгөрсөн оны 3 дугаар улиралтай харьцуулахад 16%-иар буурч 213 сая ам.доллар, зардал нь нь 12%-иар өсч 529 сая ам.доллар болсноор дансны алдагдал 43%-иар өсч 316 сая ам.долларт хүрсэн байна.

Алдагдал ийнхүү өсөхөд бусад үйлчилгээний зардал 66%-иар буюу 99 сая ам.доллараар өссөн, үүнд бизнесийн удирдлагын зөвлөх үйлчилгээний зардал 78 сая ам.доллараар өсч 87 сая ам.доллар болсон нь голчлон нөлөөлжээ.

Харин импортын бууралтаас шалтгаалан тээврийн үйлчилгээний зарлага өнгөрсөн оны мөн үеэс 30%-иар буурч 154 сая ам.долларт хүрсэн байна.

## Орлого

Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллагуудаас харьяат бус хувьцаа эзэмшигчиддээ 16 сая ам.долларын ноогдол ашгийг хуваарилж, гадны хөрөнгө оруулагчдаасаа авсан зээлийн эх үүсвэрт 149 сая ам.долларын хүү төлсөн бол Монгол Улсын Засгийн газар гадаадаас авсан зээлийн эх үүсвэрийн хүүгийн төлбөрт 7 сая ам.доллар, бондын хүүгийн төлбөрт 27 сая ам.доллар, банкууд эдийн засгийн харьяат бусийн харилцах, хадгаламжийн эх үүсвэрт 9 сая ам.долларын хүүг тус тус төлжээ. Монгол Улсад ажиллаж буй гадаад ажилтнуудад олгосон цалин хөлсний хэмжээ 38 сая ам.долларт хүрснээс шалтгаалж ажиллагсдын цалин хөлсний данс цэвэр дүнгээр 25 сая ам.долларын алдагдалтай гарсан нь 2013 оны мөн үеэс 33%-иар буурсан үзүүлэлт юм. Хөрөнгө оруулалтын орлогын данс 257 сая ам.долларын алдагдалтай гарч 2013 оны мөн үетэй харьцуулахад алдагдлын хэмжээ 2.4 дахин өсөв.

Улмаар цэвэр орлогын дансны алдагдал тайлант хугацаанд 281 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 97%-иар өссөн байна.


## Урсгал шилжүүлэг

Гадаадын улс орнуудад ажиллаж, амьдарч буй иргэдээс хүлээн авсан гуйвуулгын дүн өмнөх оны мөн үеэс 13%-иар буурсан боловч гадаадын улс орнууд руу шилжүүлсэн хувийн гуйвуулгын хэмжээ түүнээс өндөр дүнгээр буюу 9%-иар буурсан байна. Ингэснээр ажилчдын гуйвуулга цэвэр дүнгээр 8 сая ам.доллараар өсчээ.


Хүснэгт 1. Урсгал тэнцэл (сая \$)

Үзүүлэлт	3-р улирал		Өөрчлөлт	
	2013	2014	Дүн	Хувь
<b>I. Урсгал тэнцэл</b>	<b>-808</b>	<b>-320</b>	<b>-488</b>	<b>-60%</b>
<b>A. Бараа, үйлчилгээний худалдаа</b>	<b>-714</b>	<b>-76</b>	<b>-639</b>	<b>-89%</b>
а. Бараа	-494	240	-734	-149%
б. Үйлчилгээ	-220	-316	96	43%
<b>B. Цэвэр орлого</b>	<b>-143</b>	<b>-281</b>	<b>138</b>	<b>97%</b>
<b>B. Урсгал шилжүүлэг</b>	<b>49</b>	<b>37</b>	<b>-12</b>	<b>-25%</b>

Дүрслэл 5. Барааны худалдаа



Дүрслэл 6. Үйлчилгээний худалдаа



Хүснэгт 2. Ажилчдын гуйвуулга, (улсаар, мянган ам.доллар)

	Хүлээн авсан			Шилжүүлсэн		
	Мөнгөн дүн	Хувийн жин	Өсөлт	Мөнгөн дүн	Хувийн жин	Өсөлт
Солонгос	14 176	27% ▲	6%	2 533	6% ▼	-45%
Америк	7 968	15% ▼	-14%	5 719	13% ▼	-33%
Хятад	4 816	9% ▲	32%	7 530	17% ▼	-27%
Гонг Конг	884	2% ▼	-71%	7 795	17% ▲	101%
Англи	3 700	7% ▼	-8%	1 171	3% ▼	-36%
ОХУ	1 713	3% ▼	-32%	2 508	6% ▼	-4%
Сингапур	1 588	3% ▼	0%	365	1% ▼	-60%
Швейцарь	1 157	2% ▼	-33%	417	1% ▲	856%
Герман	3 560	7% ▼	-25%	1 135	3% ▲	31%
Япон	1 048	2% ▼	-42%	2 517	6% ▲	116%
Бусад	12 193	23% ▼	-18%	13 419	30% ▼	-9%
<b>НИЙТ</b>	<b>52 804</b>	<b>100%</b>		<b>45 108</b>	<b>100%</b>	

Хүснэгт 3. Ажилчдын гуйвуулга, (I улирал, сая \$)

	2012	2013	2014	Жилийн өөрчлөлт	
				Мөнгөн дүн	Хувиар
<b>Ажилчдын гуйвуулга (цэвэр)</b>	9,8	11,2	7,7	-3,5	-31%
Гаднаас орж ирсэн	77,8	60,6	52,8	-7,8	-13%
Гадагш шилжүүлсэн	-68,0	-49,5	-45,1	4,37	-9%

# I. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

## ХӨРӨНГӨ, САНХҮҮГИЙН ДАНС

Тайлант улиралд хөрөнгө ба санхүүгийн тэнцэл 657 сая ам.долларын алдагдалтай гарч өнгөрсөн оны мөн үеэс 611 сая ам.доллараар өссөн байна.

### Гадаадын шууд хөрөнгө оруулалт

Тайлант хугацаанд гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 214 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийн үзүүлэлтээс 48%-иар буюу 196 сая ам.доллараар буурчээ. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын бууралтыг данс тус бүрээр нь авч үзвэл:

- 1) Дүрмийн санд оруулсан хөрөнгө оруулалт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 71%-иар буурч, 78 сая ам.долларт;
- 2) Компанийн эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилготой зээлийн эх үүсвэрийн санхүүжилт 44%-иар буурч, 129 сая ам.долларт тус тус хүрсэн байна.

Тайлант хугацаанд орж ирсэн Гадаадын шууд хөрөнгө оруулалтын нийт эх үүсвэрийн 38% нь БНХАУ-аас, 20% нь Гонг Конгийн хөрөнгийн бирж, банк, санхүүгийн байгууллагаар дамжин санхүүжигдсэн байна. БНХАУ-аас хийгдсэн хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20%-иар өссөн бол, Гонг Конгоос хийгдсэн хөрөнгө оруулалт 76%-иар буурчээ.

### Багцын хөрөнгө оруулалт

Багцын хөрөнгө оруулалтын данс тайлант хугацаанд 31 сая ам.долларын алдагдалтай гарахад:

- (I) манай иргэд, аж ахуйн нэгжүүд гадны хуулийн этгээдийн хувьцаа, үнэт цаасыг худалдаж авахад 24 сая ам.долларыг зарцуулсан,
- (II) гадны иргэд, аж ахуйн нэгжүүд эдийн засгийн харьяатын хөрөнгийн хувьцааг худалдаж авахад 1 сая ам.долларыг төлж (орох урсгал), бонд, үнэт цаасыг 6 сая ам.доллараар худалдаж авснаар (орох урсгал) пассив 7 сая ам.долларт хүрсэн нь

### Бусад хөрөнгө оруулалт

Тайлант улиралд бусад хөрөнгө оруулалтын данс 446 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 837 сая ам.доллараар өсчээ. Энэ нь манай улсын эдийн засгийн харьяат банк, аж ахуйн нэгж, иргэдийн гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн цэвэр урсгал 499 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 356 сая ам.доллараар өссөнөөр голчлон шалтгаалжээ.

### Алдаа ба орхигдуулга

Тайлант хугацаанд алдаа ба орхигдуулга үзүүлэлт -165 сая ам.доллар гарсан байна. Түүнчлэн уг үзүүлэлт сөрөг дүнтэй гарсан нь тайлант хугацаанд гадагш чиглэсэн хөрөнгийн урсгалын төлбөр тооцоо дутуу бүртгэгдэж байж болзошгүйг харуулж байна.


Хүснэгт 4. Хөрөнгө, санхүүгийн тэнцэл (сая \$)

Үзүүлэлт	3-р улирал		Өөрчлөлт	
	2013	2014	Дүн	Хувь
<b>II. Хөрөнгө, санхүүгийн тэнцэл</b>	<b>46</b>	<b>657</b>	<b>611</b>	<b>1339%</b>
<i>A. Хөрөнгийн данс</i>	<i>33</i>	<i>27</i>	<i>-6</i>	<i>-18%</i>
<i>B. Санхүүгийн данс</i>	<i>13</i>	<i>630</i>	<i>617</i>	<i>4778%</i>
<i>а. Шууд хөрөнгө оруулалт</i>	<i>410</i>	<i>214</i>	<i>-196</i>	<i>-48%</i>
<i>Гадагш хийсэн</i>	<i>-6</i>	<i>-3</i>	<i>-3</i>	<i>-54%</i>
<i>Монгол Улсад орсон</i>	<i>415</i>	<i>216</i>	<i>-199</i>	<i>-48%</i>
<i>б. Багцын хөрөнгө оруулалт</i>	<i>-6</i>	<i>-31</i>	<i>-25</i>	<i>388%</i>
<i>в. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл</i>	<i>0</i>	<i>1</i>	<i>1</i>	
<i>г. Бусад хөрөнгө оруулалт</i>	<i>-390</i>	<i>446</i>	<i>-837</i>	<i>-214%</i>
<i>Үүнээс: Худалдааны зээл</i>	<i>-63</i>	<i>98</i>	<i>-161</i>	<i>-256%</i>
<i>Бэлэн мөнгө харилцах</i>	<i>-470</i>	<i>-211</i>	<i>-259</i>	<i>-55%</i>

Хүснэгт 5. Монгол улсад орсон ШХО (сая \$)

Үзүүлэлт	2014 он 3-р улирал		2014Q3/2013Q3 Өөрчлөлт %
	Мөнгөн дүн	Хувийн жин	
БНХАУ	78.8	38%	20% ▲
Өмнөд Солонгос	5.5	3%	-72% ▼
Канад	2.9	1%	-38% ▼
Гонг Конг	42.7	20%	-76% ▼
Япон	27.4	13%	198% ▲
ОХУ	2.2	1%	-65% ▼
Англи	3.7	2%	-18% ▼
АНУ	28.2	13%	34% ▲
Европ тив (Англи, ХБНГУ-аас бусад)	2.7	1%	-6% ▼
Австрали	6.7	3%	-2% ▼
ХБНГУ	1.6	1%	-29% ▼
Сингапур	6.4	3%	8% ▲
Бусад	0.3	0%	
Орлогын дахин хөрөнгө оруулалт	7.3	-	
<b>Нийт</b>	<b>216.3</b>	<b>100%</b>	

Дүрслэл 7. Бусад хөрөнгө оруулалт (сая \$)



Дүрслэл 8. Улсын гадаад валютын нийт албан нөөц



## II. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦ

Монгол Улсын Гадаад хөрөнгө оруулалтын позиц (цэвэр) 2014 оны 3-р улирлын эцэст -23,490 сая ам.доллар байв.

Өөрөөр хэлбэл, Монгол Улсын гаднаас татсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь гадагш хийсэн хөрөнгө оруулалтаас 23 тэрбум ам.доллараар их байна. Энэ нь гадаадын шууд хөрөнгө оруулалтын болон бусад хөрөнгө оруулалт, ялангуяа улсын өрийн үлдэгдлээс голлон хамаарч байна.

Монгол Улсаас эдийн засгийн харьяат буст оруулсан хөрөнгө оруулалтын дүн (актив) 3,569 сая ам.доллар байна. Үүний 42%-ийг гадаад валютын албан нөөц, 42%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 8%-ийг багцын хөрөнгө оруулалт, үлдсэн 8%-ийг шууд хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Монгол Улсын эдийн засгийн харьяатад гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн (пассив) 27,058 сая ам.долларт хүрчээ. Үүний 62%-ийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 27%-ийг бусад хөрөнгө оруулалтын пассив, үлдсэн 11%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын 36%-ийг буюу 6,018 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, үлдсэн 64% буюу 10,825 сая ам.долларыг толгой компаниасаа авсан зээл эзэлж байна.

Гадаад хөрөнгө оруулалтын богино позиц өмнөх оны мөн үеэс 25%-иар буюу 4,751 сая ам.доллараар нэмэгдсэн байна. Үүнийг:

- Ерөнхий бүтцээр нь авч үзвэл, гадаад актив 20%-иар буюу 896 сая ам.доллараар буурч, гадаад пассив 17%-иар буюу 3,855 сая ам.доллараар нэмэгдсэнээр,
- Данс тус бүрээр авч үзвэл, бусад хөрөнгө оруулалтын богино позиц 42%-иар буюу 1,705 сая ам.доллараар, багцын хөрөнгө оруулалт 16%-иар буюу 362 сая ам.доллараар, гадаадын шууд хөрөнгө оруулалтын богино позиц 10%-иар буюу 1,513 сая ам.доллараар тус тус өссөнөөр,
- Өөрчлөлтийг бүтцээр авч үзвэл, гадаад хөрөнгө оруулалтын богино позиц тайлант улиралд өмнөх улирлаас төлбөрийн тэнцлийн орох, гарах урсгалаар 493 сая ам.доллар, ханшийн зөрүүгээр 85 сая ам.доллараар өсч, үнийн өөрчлөлтөөр 34 сая ам.доллар болон бусад өөрчлөлтөөр 296 сая ам.доллараар буурсанаар тайлбарлагдаж байна.

### Хөрөнгийн зах зээлийн үнэ


Монгол Улсад хөрөнгө оруулсан, Олон улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдийн хувьцааны үнэ 2014 оны 3-р улиралд өмнөх улирлын хаалтын ханштай харьцуулахад дунджаар 2%-иар буурчээ.

Туркуоз хилл ресурс компанийн хувьцаа 12%-иар өсч 3.74 ам.доллар болсон бол Монголийн майнинг корпорацийн хувьцаа 21%-иар өсч 0.6 хонгконг долларт хүрсэн байна. Харин Сентерра гоулд, Саусгоби сэндс, Монголийн энерги корпорацийн хувтцаанууд харгалзан 25%, 12%, 21%-иар тус тус буурсан байна.

Хүснэгт 7. Позит (сая ам.доллар)

Үзүүлэлт	9/30/2013	9/30/2014	Өөрчлөлт	
			Дүн	Дахин
Гадаад хөрөнгө оруулалтын позиц	-18,739	-23,490	-4,751	1.3
<b>I. Гадаад актив</b>	<b>4,465</b>	<b>3,569</b>	<b>-896</b>	<b>0.8</b>
1. Шууд хөрөнгө оруулалт	215	268	53	1.2
2. Багцын хөрөнгө оруулалт	388	285	-103	0.7
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	0	2	2	0.0
4. Бусад хөрөнгө оруулалт	1,183	1,504	321	1.3
5. Нөөц актив	2,680	1,510	-1,169	0.6
<b>II. Гадаад пассив</b>	<b>23,204</b>	<b>27,058</b>	<b>3,855</b>	<b>1.2</b>
1. Шууд хөрөнгө оруулалт	15,278	16,843	1,565	1.1
2. Багцын хөрөнгө оруулалт	2,648	2,908	259	1.1
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	0	4	4	0.0
4. Бусад хөрөнгө оруулалт	5,278	7,304	2,026	1.4

Дүрслэл 9. Гадаад актив



Дүрслэл 10. Гадаад пассив



Хүснэгт 8. Олон улсын хөрөнгийн бирж дээрх хувьцааны үнэ

№	Компанийн нэр	Симбол	Бирж	Мөнгөн тэмдэгт	Хаалтын үнэ		Өөрчлөлт
					6/30/2014	9/30/2014	
1	Turquoise Hill Resources	TRQ.US	US	USD	3.34	3.74	12.0%
2	Mongolian Mining Corp	0975.HK	HK	HKD	0.49	0.59	20.7%
3	Centerra Gold	CG.TO	CAD	CAD	6.73	5.02	-25.4%
4	Southgobi Resources	1878.HK	HK	HKD	5.10	4.46	-12.5%
5	Winsway Cocking Coal	1733.HK	HK	HKD	0.40	0.32	-20.0%
6	Mongolia Energy Corp	0276.HK	HK	HKD	0.86	0.68	-21.4%
7	Petro Matad	MAT.D.L	LN	GBP	2.75	2.88	4.5%
8	Prophecy Coal Corp	PCY.TO	CAD	CAD	0.05	0.06	20.0%
9	Haranga resources	HAR.AX	AU	AUD	0.04	0.03	-25.0%
10	Peace Map Holding Limited	0402.HK	HK	HKD	0.20	0.26	30.0%



### III. ГАДААД ӨРИЙН СТАТИСТИК

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2014 оны 3-р улирлын байдлаар 20,951 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 2,671 сая ам.доллараар нэмэгдсэн байна. Үүнийг салбараар нь авч үзвэл:

**Улсын салбар:** Засгийн газар, Монголбанкны гадаад өр 482 сая ам.доллараар нэмэгдэж 5,031 сая ам.долларт хүрчээ.

**Хувийн хэвшил:** Банк, бусад сектор, хөрөнгө оруулагчийн зээлийг бүхэлд нь хувийн хэвшлийн салбарын гадаад өр гэж ойлгох бөгөөд өнгөрсөн жилийн хугацаанд 2,189 сая ам.доллараар нэмэгдэж 15,919 сая ам.долларт хүрээд байна.

#### Банкны салбар

Банкны салбарын гадаад пассивын үлдэгдэл 2014 оны 3-р улирлын байдлаар 1,513 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 23%-иар буюу 280 сая ам.доллараар нэмэгджээ.

Гадаад пассивын 43%-ийг урт хугацаат зээл, 30%-ийг бонд, өрийн бичиг, 17%-ийг богино хугацаат зээл, үлдсэн 9%-ийг оршин суугч бусын харилцах, хадгаламжийн дансны өглөг тус тус бүрдүүлж байна.

Банкууд тайлант улиралд гадаадын банк, санхүүгийн байгууллагаас 60 сая ам.долларын урт хугацаат, 68 сая ам.долларын богино хугацаат зээлийн шинээр авч, зээлийн гэрээнд заасан хуваарийн дагуу харгалзан 12 сая ам.доллар, 23 сая ам.долларын үндсэн төлбөрийг буцаан төлснөөр зээлийн үлдэгдэл 538 сая ам.доллар, 258 сая ам.долларт тус тус хүрчээ.

#### Банкны бус салбар

Банк бус салбарын буюу аж ахуйн нэгж, иргэдийн гадаад пассив 2014 оны 3-р улирлын эцэст 14,407 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 15%-иар буюу 1,909 сая ам.доллараар нэмэгдсэн.

Салбарын нийт зээлийн 75% буюу 10,825 сая ам.долларын эх үүсвэр нь аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулагчийн зээл буюу компани хоорондын өглөг бөгөөд үүний дийлэнх нь уул уурхайн салбарт ашиглагдсан байна. Эх үүсвэр нь компаний эргэлтийн хөрөнгө, мөнгөн урсгалыг дэмжих зорилгоор олгогддог урт хугацаат санхүүжилт бөгөөд ихэнх тохиолдолд хүүгүй, хатуу мөрдөх эргэн төлөлтийн хуваарь үгүй, улмаар харилцан тохиролцсоны үндсэн дээр цаашид дүрмийн санд нэмж тооцогдох боломжтой байдгаараа бусад төрлийн зээлээс ялгаатай юм.


Хөрөнгө оруулагчдын санхүүжилтийн ашиглалт болон буцаан төлөлтийн байдлыг үзвэл тайлант улиралд 296 сая ам.доллар, 167 сая ам.доллар тус тус байжээ.

ААНБ-уудын экспортын бараа, үйлчилгээнд авсан урьдчилгаа төлбөр болон төлбөрийг хийгээгүй боловч хүлээн авсан импортын бараа үйлчилгээний урт, богино хугацаат өглөгийн үлдэгдэл тайлант улирлын байдлаар 633 сая ам.доллар болсон байна.


**Хүснэгт 9. Нийт гадаад өрийн үлдэгдэл (сая ам.доллар)**

Үзүүлэлт	9/30/2013	9/30/2014	Өөрчлөлт	
			Дүн	Дахин
<b>Нийт гадаад өр</b>	<b>18,280</b>	<b>20,951</b>	<b>2,671</b>	<b>1.1</b>
<b>I. Засгийн газар</b>	<b>3,657</b>	<b>3,596</b>	<b>-61</b>	<b>1.0</b>
<b>II. Төв банк</b>	<b>892</b>	<b>1,435</b>	<b>543</b>	<b>1.6</b>
<b>III. Банк</b>	<b>1,233</b>	<b>1,513</b>	<b>280</b>	<b>1.2</b>
Богино хугацаат	82	258	176	3.1
Урт хугацаат	1,151	1,255	104	1.1
<b>IV. Бусад сектор</b>	<b>2,469</b>	<b>3,582</b>	<b>1,113</b>	<b>1.5</b>
Богино хугацаат	469	551	82	1.2
Урт хугацаат	2,000	3,031	1,031	1.5
<b>V. Хөрөнгө оруулагчаас авсан зээл</b>	<b>10,029</b>	<b>10,825</b>	<b>796</b>	<b>1.1</b>

**Дүрслэл 11. Банкны салбарын гадаад зээл**



**Дүрслэл 12. Банк бус хувийн хэвшлийн гадаад зээл**



#### Мэдээллийн эх сурвалж:

1. Засгийн газрын гадаад өр: Сангийн яам, Өрийн удирдлагын хэлтэс
2. Монголбанк: Монголбанк, ТТБГазар, ВЭЗГазар
3. Банк: Арилжааны банкуудын тайлан тэнцэл, Төлбөрийн тэнцлийн мэдээ, Гадаад зээлийн бүртгэл
4. Банк бус салбар: ААН-ийн Төлбөрийн тэнцлийн улирлын мэдээ, Банкуудын гадаад гүйлгээний тайлан, Гадаад зээлийн бүртгэлийн мэдээллийг тус тус ашиглав.

**ХАВСРАЛТ 1. МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ХУРААНГУЙ ХҮСНЭГТ (сая ам.доллар)**

Үзүүлэлт	3 дугаар улирал			Өөрчлөлт				Дундаж, сүүлийн		
	2012	2013	2014	Дүн	2013/12	Дүн	2014/13	3 сар	6 сар	9 сар
<b>I. Урсгал Тэнцэл</b>	<b>-1,190</b>	<b>-808</b>	<b>-320</b>	<b>382</b>	<b>-32%</b>	<b>488</b>	<b>-60%</b>	<b>-78</b>	<b>-127</b>	<b>-133</b>
<b>А. Бараа ба үйлчилгээний худалдаа</b>	<b>-986</b>	<b>-714</b>	<b>-76</b>	<b>272</b>	<b>-28%</b>	<b>639</b>	<b>-89%</b>	<b>-4</b>	<b>-75</b>	<b>-87</b>
<b>1. Бараа</b>	<b>-757</b>	<b>-494</b>	<b>240</b>	<b>263</b>	<b>-35%</b>	<b>734</b>	<b>-149%</b>	<b>100</b>	<b>42</b>	<b>28</b>
1.1 Ерөнхий эд бараа	-773	-597	133	176	-23%	730	-122%	64	22	10
Экспорт Ф.О.Б. (Кредит)	943	963	1,417	20	2%	454	47%	508	472	418
Үүнээс: Засийн	205	275	698	70	34%	423	153%	244	211	172
Импорт Ф.О.Б. (Дебит)	-1,715	-1,560	-1,283	156	-9%	276	-18%	-444	-450	-408
Үүнээс: Непфийн	-405	-338	-321	67	-17%	17	-5%	-102	-102	-97
Хүнсний	-112	-125	-115	-13	12%	10	-8%	-40	-41	-39
1.2 Мөнгөжөөгүй алт	25	110	124	85	341%	14	13%	41	25	24
Кредит	25	110	124	85	341%	14	13%	41	25	24
Дебит	0	0	0	0	0%	0	0%	0	0	0
1.3 Бусад	-9	-8	-18	1	-14%	-10	121%	-5	-6	-2
Кредит	1	1	0	-1	-54%	0	-27%	0	0	0
Дебит	-11	-9	-18	2	-19%	-10	110%	-5	-6	-7
<b>2. Үйлчилгээ</b>	<b>-229</b>	<b>-220</b>	<b>-316</b>	<b>9</b>	<b>-4%</b>	<b>-96</b>	<b>43%</b>	<b>-104</b>	<b>-117</b>	<b>-115</b>
<b>2.1 Тээвэр</b>	<b>-238</b>	<b>-160</b>	<b>-96</b>	<b>78</b>	<b>-33%</b>	<b>63</b>	<b>-40%</b>	<b>-35</b>	<b>-41</b>	<b>-41</b>
Кредит	69	61	58	-8	-12%	-3	-5%	20	18	18
Дебит	-307	-221	-154	86	-28%	66	-30%	-55	-59	-59
<b>2.2 Аялал</b>	<b>54</b>	<b>-6</b>	<b>-22</b>	<b>-60</b>	<b>-111%</b>	<b>-16</b>	<b>264%</b>	<b>0</b>	<b>-9</b>	<b>-15</b>
Кредит	176	98	104	-78	-44%	6	6%	36	23	17
Дебит	-122	-104	-126	18	-14%	-22	21%	-36	-32	-32
<b>2.3 Бусад үйлчилгээ</b>	<b>-45</b>	<b>-54</b>	<b>-197</b>	<b>-9</b>	<b>20%</b>	<b>-143</b>	<b>264%</b>	<b>-69</b>	<b>-66</b>	<b>-60</b>
Кредит	82	95	51	13	16%	-44	-46%	19	18	19
Дебит	-127	-149	-248	-22	17%	-99	66%	-87	-85	-79
<b>В. Орлого</b>	<b>-250</b>	<b>-143</b>	<b>-281</b>	<b>107</b>	<b>-43%</b>	<b>-138</b>	<b>97%</b>	<b>-86</b>	<b>-66</b>	<b>-62</b>
<b>1. Ажиллагсдын цалин хөлс</b>	<b>-61</b>	<b>-37</b>	<b>-25</b>	<b>24</b>	<b>-40%</b>	<b>12</b>	<b>-33%</b>	<b>-9</b>	<b>-7</b>	<b>-8</b>
Кредит	7	10	13	3	44%	2	24%	4	5	5
Дебит	-69	-47	-38	21	-31%	10	-21%	-13	-12	-13
<b>2. Хөрөнгө оруулалтын орлого</b>	<b>-188</b>	<b>-106</b>	<b>-257</b>	<b>82</b>	<b>-44%</b>	<b>-151</b>	<b>142%</b>	<b>-77</b>	<b>-59</b>	<b>-54</b>
Кредит	1	1	0	0	33%	-1	-78%	0	0	0
Дебит	-189	-107	-257	82	-43%	-150	139%	-77	-59	-54
<b>С. Урсгал шилжүүлэг (цэвэр)</b>	<b>45</b>	<b>49</b>	<b>37</b>	<b>4</b>	<b>9%</b>	<b>-12</b>	<b>-25%</b>	<b>11</b>	<b>15</b>	<b>16</b>
Кредит	127	104	83	-23	-18%	-21	-20%	28	30	30
Дебит	-82	-55	-46	27	-33%	9	-16%	-17	-16	-14
Үүнээс: Ажиллагсдын гуйвуулга	2	11	8	9	598%	-3	-27%	0	3	4
Кредит	82	61	53	-21	-26%	-8	-13%	16	18	18
Дебит	-80	-50	-45	30	-37%	5	-10%	-16	-14	-13
	0	0	0							
<b>II. Хөрөнгө ба Санхүүгийн Тэнцэл</b>	<b>864</b>	<b>46</b>	<b>657</b>	<b>-818</b>	<b>-95%</b>	<b>611</b>	<b>1339%</b>	<b>70</b>	<b>-7</b>	<b>32</b>
<b>А. Хөрөнгийн данс</b>	<b>28</b>	<b>33</b>	<b>27</b>	<b>5</b>	<b>17%</b>	<b>-6</b>	<b>-18%</b>	<b>9</b>	<b>10</b>	<b>11</b>
<b>В. Санхүүгийн данс</b>	<b>836</b>	<b>13</b>	<b>630</b>	<b>-823</b>	<b>-98%</b>	<b>617</b>	<b>4778%</b>	<b>60</b>	<b>-17</b>	<b>21</b>
<b>1. Шууд хөрөнгө оруулалт</b>	<b>1,299</b>	<b>410</b>	<b>214</b>	<b>-889</b>	<b>-68%</b>	<b>-196</b>	<b>-48%</b>	<b>63</b>	<b>65</b>	<b>84</b>
1.1 Гадагш хийсэн	-22	-6	-3	16	-74%	3	-54%	-3	-2	-2
1.1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө	-21	-6	-3	15	-70%	4	-60%	-3	-1	-2
1.1.2 Орлогын дахин хөрөнгө	0	0	0	0	0%	0	0%	0	0	0
1.1.3 Бусад хөрөнгө	-1	1	0	1	0%	-1	0%	0	0	0
1.2 Монголд орсон	1,321	415	216	-905	-69%	-199	-48%	66	66	86
1.2.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө	238	276	80	38	16%	-195	-71%	30	36	34
1.2.2 Орлогын дахин хөрөнгө	45	-91	7	-136	-301%	98	-108%	-3	-15	-21
1.2.3 Бусад хөрөнгө	1,038	231	129	-807	-78%	-102	-44%	39	46	72
<b>2. Багцын хөрөнгө оруулалт</b>	<b>260</b>	<b>-6</b>	<b>-31</b>	<b>-266</b>	<b>-102%</b>	<b>-25</b>	<b>388%</b>	<b>-1</b>	<b>-1</b>	<b>38</b>
2.1 Актив	-22	-1	-24	21	-94%	-23	1846%	-2	-3	-4
2.1.1 Хөрөнгийн хувьцаа	-22	-1	-11	21	-96%	-10	1039%	-2	-3	-2
2.1.2 Өрийн бичиг	0	0	-13	0	-74x	-13	46.8552	0	0	-2
2.2 Пассив	282	-5	-7	-287	-102%	-2	-35x	1	2	42
2.2.1 Хөрөнгийн хувьцаа	4	0	-1	-3	-88%	-1	-259%	-1	1	1
2.2.2 Өрийн бичиг	279	-6	-6	-284	-102%	-1	13%	2	1	41
<b>3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0%</b>	<b>1</b>	<b>0%</b>	<b>3</b>	<b>0</b>	<b>0</b>
3.1 Актив	0	0	1	0	0%	3	0%	0	1	2
3.2 Пассив	0	0	-1	0	0%	-1	0%	0	0	0
<b>4. Бусад хөрөнгө оруулалт</b>	<b>-722</b>	<b>-390</b>	<b>446</b>	<b>332</b>	<b>-46%</b>	<b>837</b>	<b>-214%</b>	<b>-5</b>	<b>-82</b>	<b>-102</b>
4.1 Актив	-687	-563	-407	125	-18%	155	-28%	-64	-126	-145
4.1.1 Худалдааны зээл	-51	-113	19	-62	121%	132	-117%	0	-14	-20
4.1.2 Зээл	0	-1	-45	-1	2260%	-44	7425%	-16	-8	-5
4.1.3 Бэлэн мөнгө ба харилцах	-636	-449	-382	187	-29%	67	-15%	-48	-104	-120
4.1.4 Бусад актив	0	0	0	0	0%	0	0%	0	0	0
4.2 Пассив	-35	172	854	208	-590%	681	395%	60	44	43
4.2.1 Худалдааны зээл	-68	50	79	118	-173%	29	58%	12	6	11
4.2.2 Зээл	69	143	544	74	107%	401	280%	51	41	34
4.2.3 Бэлэн мөнгө ба харилцах	-36	-20	171	16	-43%	192	-937%	-5	-4	-2
4.2.4 Бусад пассив	0	0	60	0	0%	60	0%	2	1	1
<b>III. Алдаа болон орхигдуулга</b>	<b>311</b>	<b>327</b>	<b>-165</b>	<b>16</b>	<b>5%</b>	<b>-492</b>	<b>-151%</b>	<b>-87</b>	<b>-26</b>	<b>-18</b>
Төлбөрийн тэнцлийн нийт дүн	-16	-436	172	-420		608	-139%	-96	-161	-119
<b>IV. Гадаад валютын цэвэр нөөцийн өөрчлөлт*</b>	<b>16</b>	<b>436</b>	<b>-172</b>	<b>420</b>	<b>2665%</b>	<b>-608</b>	<b>-139%</b>	<b>96</b>	<b>161</b>	<b>119</b>
<b>1. Актив</b>	<b>32</b>	<b>460</b>	<b>-163</b>	<b>428</b>	<b>-623</b>	<b>96</b>	<b>161</b>	<b>119</b>		
1.1 Мөнгөжсөн алт	-10	73	0	83	-73	0	0	0	0	4
1.2 Зээлжих тусгай эрх	0	0	0	1	0	0	0	0	0	0
1.3 ОУВС-д байршуулсан хөрөнгө	0	0	0	0	0	0	0	0	0	0
1.4 Бэлэн валют ба харилцах	32	387	-164	355	-550	96	161	115		
1.5 Бусад нөөц актив	10	0	0	-10	0	0	0	0	0	0
<b>2. Пассив</b>	<b>-16</b>	<b>-24</b>	<b>-9</b>	<b>-8</b>	<b>15</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
2.1 ОУВС-ийн зээл	-16	-24	-9	-8	15	0	0	0	0	0
2.2 Онцгой санхүүжилт	0	0	0	0	0	0	0	0	0	0

\* [-] утга нь өсөлтийг, [+] утга нь бууралтыг тус тус илэрхийлнэ.

**ХАВСРАЛТ 2. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН (мянган ам.доллар)**

Үзүүлэлт	9/30/2011	9/30/2012	9/30/2013	12/31/2013	3/31/2014	6/30/2014	9/30/2014
<b>Гадаад хөрөнгө оруулалтын позиц (цэвэр)</b>	<b>-6,422</b>	<b>-12,786</b>	<b>-18,739</b>	<b>-19,857</b>	<b>-20,865</b>	<b>-22,786</b>	<b>-23,490</b>
<b>I. Гадаад актив</b>	<b>6,150</b>	<b>5,118</b>	<b>4,465</b>	<b>4,005</b>	<b>3,911</b>	<b>3,136</b>	<b>3,569</b>
<b>1. Шууд хөрөнгө оруулалт (гадаад руу)</b>	<b>2,198</b>	<b>1,082</b>	<b>215</b>	<b>258</b>	<b>259</b>	<b>266</b>	<b>268</b>
1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө ба ашгийн дахин хөрөнгө оруулалт	2,196	1,081	211	252	253	258	261
1.1.1 Салбар компаниас авах	2,196	1,081	211	252	253	258	261
1.1.2 Салбар компанид өгөх (-)	0	0	0	0	0	0	0
1.2 Бусад хөрөнгө	2	1	5	6	6	7	7
1.2.1 Салбар компаниас авах	2	1	5	6	6	7	7
1.2.2 Салбар компанид өгөх (-)	0	0	0	0	0	0	0
<b>2. Багцын хөрөнгө оруулалт</b>	<b>92</b>	<b>54</b>	<b>388</b>	<b>387</b>	<b>324</b>	<b>291</b>	<b>285</b>
2.1 Хөрөнгийн хувьцаа	12	49	378	379	300	266	246
2.1.1 Төв банк	0	0	0	0	0	0	0
2.1.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0
2.1.3 Банкууд	0	0	0	0	0	0	0
2.1.4 Бусад салбар	12	49	378	379	300	266	246
2.2 Өрийн бичиг	80	5	9	9	24	25	38
2.2.1 Бонд, үнэт цаас	76	0	4	0	0	2	15
2.2.1.1 Төв банк	0	0	0	0	0	0	0
2.2.1.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0
2.2.1.3 Банкууд	0	0	4	0	0	0	0
2.2.1.4 Бусад салбар	76	0	0	0	0	1	15
2.2.2 Мөнгөний захын хэрэгсэл	4	4	5	8	23	24	24
2.2.2.1 Төв банк	0	0	0	0	0	0	0
2.2.2.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0
2.2.2.3 Банкууд	0	0	0	0	0	0	0
2.2.2.4 Бусад салбар	4	4	5	8	23	24	24
<b>3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>5</b>	<b>5</b>	<b>2</b>
3.1 Төв банк	0	0	0	0	0	0	0
3.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0
3.3 Банкууд	0	0	0	0	5	5	2
3.4 Бусад салбар	0	0	0	0	0	0	0
<b>4. Бусад хөрөнгө оруулалт</b>	<b>1,255</b>	<b>1,078</b>	<b>1,183</b>	<b>1,112</b>	<b>1,379</b>	<b>1,257</b>	<b>1,504</b>
<b>4.1 Худалдааны зээллэг</b>	<b>276</b>	<b>398</b>	<b>531</b>	<b>540</b>	<b>685</b>	<b>572</b>	<b>562</b>
4.1.1 Засгийн газар	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0
4.1.2 Бусад салбар	276	398	531	540	685	572	562
Урт хугацааны	28	102	24	5	11	8	6
Богино хугацааны	248	296	507	534	675	564	556
<b>4.2 Зээл</b>	<b>9</b>	<b>21</b>	<b>17</b>	<b>5</b>	<b>5</b>	<b>6</b>	<b>52</b>
4.2.1 Төв банк	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0
4.2.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0
4.2.3 Банкууд	9	21	13	2	2	4	49
Урт хугацааны	0	0	0	0	0	0	45
Богино хугацааны	9	21	13	2	2	4	4
4.2.4 Бусад салбар	0	0	4	3	3	2	3
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	4	3	3	2	3
<b>4.3 Бэлэн мөнгө ба харилцах</b>	<b>970</b>	<b>660</b>	<b>634</b>	<b>567</b>	<b>689</b>	<b>678</b>	<b>890</b>
4.3.1 Төв банк	0	0	0	0	0	0	0
4.3.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0
4.3.3 Банкууд	452	396	522	494	572	499	581
4.3.4 Бусад салбар	518	263	112	73	117	180	310
<b>4.4 Бусад актив</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
4.4.1 Төв банк	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0
4.4.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0
4.4.3 Банкууд	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0
4.4.4 Бусад салбар	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0
<b>5. Нөөц актив</b>	<b>2,606</b>	<b>2,904</b>	<b>2,680</b>	<b>2,248</b>	<b>1,943</b>	<b>1,318</b>	<b>1,510</b>

Үргэлжлэл.

Үзүүлэлт	9/30/2011	9/30/2012	9/30/2013	12/31/2013	3/31/2014	6/30/2014	9/30/2014
<b>II. Гадаад пассив</b>	<b>12,573</b>	<b>17,904</b>	<b>23,204</b>	<b>23,862</b>	<b>24,775</b>	<b>25,922</b>	<b>27,058</b>
<b>1. Шууд хөрөнгө оруулалт (гадаадаас)</b>	<b>8,855</b>	<b>12,771</b>	<b>15,278</b>	<b>15,729</b>	<b>16,022</b>	<b>16,677</b>	<b>16,843</b>
1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө ба ашгийн дахин хөрөнгө оруулалт	3,419	4,780	5,248	5,388	5,356	6,003	6,018
1.1.1 Хөрөнгө оруулагчаас авах	0	0	0	0	0	0	0
1.1.2 Хөрөнгө оруулагчид өгөх (-)	3,419	4,780	5,248	5,388	5,356	6,003	6,018
1.2 Бусад хөрөнгө	5,436	7,992	10,029	10,341	10,665	10,674	10,825
1.2.1 Хөрөнгө оруулагчаас авах	0	0	0	0	0	0	0
1.2.2 Хөрөнгө оруулагчид өгөх (-)	5,436	7,992	10,029	10,341	10,665	10,674	10,825
<b>2. Багцын хөрөнгө оруулалт</b>	<b>325</b>	<b>1,204</b>	<b>2,648</b>	<b>2,470</b>	<b>2,872</b>	<b>2,876</b>	<b>2,908</b>
<b>2.1 Хөрөнгийн хувьцаа</b>	<b>104</b>	<b>102</b>	<b>86</b>	<b>35</b>	<b>89</b>	<b>87</b>	<b>86</b>
2.1.1 Банкууд	0	0	0	0	0	0	0
2.1.2 Бусад салбар	104	102	86	35	89	87	86
<b>2.2 Өрийн бичиг</b>	<b>221</b>	<b>1,102</b>	<b>2,562</b>	<b>2,435</b>	<b>2,783</b>	<b>2,789</b>	<b>2,821</b>
2.2.1 Бонд, үнэт цаас	221	1,102	2,562	2,435	2,783	2,789	2,821
2.2.1.1 Төв банк	0	0	0	0	0	0	0
2.2.1.2 Засгийн газар	28	600	2,080	2,080	2,317	2,317	1,500
2.2.1.3 Банкууд	192	500	478	351	462	463	461
2.2.1.4 Бусад салбар	1	1	4	4	4	10	860
2.2.2 Мөнгөний захын хэрэгсэл	0	0	0	0	0	0	0
2.2.2.1 Төв банк	0	0	0	0	0	0	0
2.2.2.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0
2.2.2.3 Банкууд	0	0	0	0	0	0	0
2.2.2.4 Бусад салбар	0	0	0	0	0	0	0
<b>3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>5</b>	<b>5</b>	<b>4</b>
3.1 Төв банк	0	0	0	0	0	0	0
3.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0
3.3 Банкууд	0	0	0	0	5	5	4
3.4 Бусад салбар	0	0	0	0	0	0	0
<b>4. Бусад хөрөнгө оруулалт</b>	<b>3,392</b>	<b>3,928</b>	<b>5,278</b>	<b>5,662</b>	<b>5,877</b>	<b>6,363</b>	<b>7,304</b>
<b>4.1 Худалдааны зээллэг</b>	<b>111</b>	<b>202</b>	<b>472</b>	<b>511</b>	<b>587</b>	<b>549</b>	<b>633</b>
4.1.1 Засгийн газар	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0
4.1.2 Бусад салбар	111	202	472	511	587	549	633
Урт хугацааны	3	53	280	339	358	332	357
Богино хугацааны	108	149	192	173	229	217	276
<b>4.2 Зээл</b>	<b>3,094</b>	<b>3,327</b>	<b>4,087</b>	<b>4,427</b>	<b>4,572</b>	<b>4,552</b>	<b>5,054</b>
4.2.1 Төв банк	275	252	75	75	75	75	73
ОУВС-гийн зээл	275	252	75	75	75	75	73
Бусад урт хугацааны	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0
4.2.2 Засгийн газар	1,808	1,978	2,157	2,184	2,188	2,172	2,096
Урт хугацааны	1,808	1,978	2,157	2,184	2,188	2,172	2,096
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0
4.2.3 Банкууд	249	279	443	629	680	698	796
Урт хугацааны	169	191	361	429	482	483	539
Богино хугацааны	80	88	82	200	198	215	258
4.2.4 Бусад салбар	761	818	1,412	1,538	1,629	1,606	2,089
Урт хугацааны	399	429	1,135	1,305	1,404	1,366	1,813
Богино хугацааны	363	389	277	233	225	240	275
<b>4.3 Бэлэн мөнгө ба харилцах</b>	<b>64</b>	<b>97</b>	<b>169</b>	<b>160</b>	<b>153</b>	<b>136</b>	<b>1,445</b>
4.3.1 Төв банк	0	0	0	0	0	0	1,302
4.3.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0
4.3.3 Банкууд	64	97	169	160	153	136	143
4.3.4 Бусад салбар	0	0	0	0	0	0	0
<b>4.4 Бусад пассив</b>	<b>124</b>	<b>303</b>	<b>550</b>	<b>564</b>	<b>564</b>	<b>1,127</b>	<b>172</b>
4.4.1 Төв банк	0	209	407	407	407	965	60
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	209	407	407	407	965	60
4.4.2 Засгийн газар	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0
4.4.3 Банкууд	124	94	143	157	157	162	112
Урт хугацааны	124	94	143	157	157	162	112
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0
4.4.4 Бусад салбар	0	0	0	0	0	0	0
Урт хугацааны	0	0	0	0	0	0	0
Богино хугацааны	0	0	0	0	0	0	0



**ХАВСРАЛТ 3. МОНГОЛ УЛСЫН НИЙТ ГАДААД ӨР (мянган ам.доллар)**

Үзүүлэлт	9/30/2011	9/30/2012	9/30/2013	12/31/2013	3/31/2014	6/30/2014	9/30/2014
<b>1. Засгийн газар</b>	<b>1,836</b>	<b>1,998</b>	<b>3,657</b>	<b>3,684</b>	<b>3,688</b>	<b>3,672</b>	<b>3,596</b>
<b>1.1 Богино хугацаат</b>	0	0	0	0	0	0	0
Харилцах, хадгаламж 5/ Өрийн бичиг 4/ Зээл Худалдааны зээл болон урьдчилгаа Бусад өглөг 6/							
<b>1.2 Урт хугацаат</b>	1,836	1,998	3,657	3,684	3,688	3,672	3,596
Зээлжих тусгай эрх (ЗТЭ), Хуваарилалт 7/ Харилцах, хадгаламж 5/ Өрийн бичиг 4/ Зээл Худалдааны зээл болон урьдчилгаа Бусад өглөг 6/	28 1,808	20 1,978	1,500 2,157	1,500 2,184	1,500 2,188	1,500 2,172	1,500 2,096
<b>2. Төвбанк</b>	<b>275</b>	<b>553</b>	<b>892</b>	<b>1,065</b>	<b>1,042</b>	<b>1,040</b>	<b>1,435</b>
<b>2.1 Богино хугацаат</b>	0	302	817	990	967	965	1,302
Харилцах, хадгаламж 5/ Өрийн бичиг 4/ Зээл Худалдааны зээл болон урьдчилгаа Бусад өглөг 6/		302	817	990	967	965	1,302
<b>2.2 Урт хугацаат</b>	275	252	75	75	75	75	133
Зээлжих тусгай эрх (ЗТЭ), Хуваарилалт 7/ Харилцах, хадгаламж 5/ Өрийн бичиг 4/ Зээл Худалдааны зээл болон урьдчилгаа Бусад өглөг 6/	77 199	75 177	75 0	75 0	75 0	75 0	73 0 60
<b>3. Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)</b>	<b>628</b>	<b>968</b>	<b>1,233</b>	<b>1,298</b>	<b>1,453</b>	<b>1,459</b>	<b>1,513</b>
<b>3.1 Богино хугацаат</b>	80	88	82	200	198	215	258
Харилцах, хадгаламж 5/ Өрийн бичиг 4/ Зээл Худалдааны зээл болон урьдчилгаа Бусад өглөг 6/	80	88	82	200	198	215	258
<b>3.2 Урт хугацаат</b>	548	881	1,151	1,098	1,254	1,244	1,255
Харилцах, хадгаламж 5/ Өрийн бичиг 4/ Зээл Худалдааны зээл болон урьдчилгаа Бусад өглөг 6/	64 192 293	97 500 283	169 478 504	160 351 586	153 462 639	136 463 645	143 461 651
<b>4. Бусад салбарууд</b>	<b>873</b>	<b>1,601</b>	<b>2,469</b>	<b>2,633</b>	<b>3,094</b>	<b>3,041</b>	<b>3,582</b>
<b>4.1 Богино хугацаат</b>	471	538	469	406	455	457	551
Харилцах, хадгаламж 5/ Өрийн бичиг 4/ Зээл Худалдааны зээл болон урьдчилгаа Бусад өглөг 6/	363 108	389 149	277 192	233 173	225 229	240 217	275 276
<b>4.2 Урт хугацаат</b>	402	1,063	2,000	2,228	2,640	2,584	3,031
Харилцах, хадгаламж 5/ Өрийн бичиг 4/ Зээл Худалдааны зээл болон урьдчилгаа Бусад өглөг 6/	1 399 3	581 429 53	584 1,135 280	584 1,305 339	878 1,404 358	885 1,366 332	860 1,813 357
<b>5 Шууд хөрөнгө оруулалт: Компани хоорондын зээллэг</b>	<b>5,436</b>	<b>7,992</b>	<b>10,029</b>	<b>10,341</b>	<b>10,665</b>	<b>10,674</b>	<b>10,825</b>
Шууд хөрөнгө оруулагчид өгөх өглөг Шууд хөрөнгө оруулагчийн өгөх өглөг Хамааралт ай компани хоорондын өглөг	5,436	7,992	10,029	10,341	10,665	10,674	10,825
<b>Нийт гадаад өр</b>	<b>9,049</b>	<b>13,112</b>	<b>18,280</b>	<b>19,022</b>	<b>19,942</b>	<b>19,886</b>	<b>20,951</b>